



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ 7 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

### Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

#### **1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

2016 оны сонгуулийн үр дүнгээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргаар Г.Бямбаа, аймгийн Засаг даргаар Ш.Оргил сонгогдон ажлаа хүлээж авч үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулах ажлаа эхлүүлээд байна.

Тулгар төрийн 2225, Их монгол улс байгуулагдсаны 810, Ардын хувьсгалын 95 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 85 жилийн ойн баяр наадмыг 2015 оны 7-р сарын 15-16-ны өдрүүдэд өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол шийдвэр, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хагас жилийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлээ.

2016 оны 2-р улирлын байдлаар иргэдээс төр захиргааны байгууллагад нийт 13658 өргөдөл ирүүлснээс 12065 өргөдлийг шийдвэрлэж 1354 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж, шийдвэрлэлт 88.3 хувьтай байна.

Аймгийн төв Сүхбаатар сумын Хонгор морьтын 1 дүгээр багт иргэд, хүүхэд залуучууд, настан буурлууд амарч зугаалах, нялх балчируудаа салхилуулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цогц байгууламжтай болох боломжийг бүрдүүлсэн иж бүрэн байгууламжийн эхний бүтээн байгуулалт болох гар бөмбөгийн талбай бүхий сагсан бөмбөгийн спорт тоглоомын талбай албан ёсоор ашиглалтанд орлоо.

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл хуралдаж, Байгаль орчин, аялал жуулчлалын ойн албаны дарга Г.Цэнгэлзаяа, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Д.Нансалмаа нарт Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдэг гардуулах, Нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн Н.Нарангэрэл, Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын газрын даамал Т.Саранцэцэг, Жавхлант сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн Б.Сарантуяа, Сүхбаатар сумын иргэн Д.Бат-Итгэл нараас аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын тухай, сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүгч С.Нолхоосүрэн, Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Д.Энхцэцэг, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Оюун, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга Б.Дарихжав, аймгийн Онцгой байдлын газрын дарга Б.Баатар нарын хүмүүсийг Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнуулах тухай асуудлуудыг тус тус хэлэлцлээ.

### Бусад ажлын талаар:

#### **Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

Сүхбаатар, Шаамар сумын 6 аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 5 худалдаа, үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, үнэлгээний дүн, холбогдох мэдээллийг сумын орон тооны бус баталгаажуулалтын салбар зөвлөлд танилцуулахаар бэлтгэлээ.

Сүхбаатар сумын “Сэлэнгэ” талхан цехийн үйлдвэрлэж буй “Хмелийн талх”, Шаамар сумын “Аргангат” нөхөрлөлийн “Шижир” нэрийн зөгийн бал зэрэг бүтээгдэхүүний “Үндэсний тохирлын тэмдэг” хэрэглэх эрхийн хугацаа дууссантай холбогдуулан баталгаажуулалтанд хамрагдах бэлтгэл ажлыг ханган, Шаамар сумын “Мон Апи” ХХК-ийн шинээр үйлдвэрлэж эхлээд буй 4 төрлийн



# СЭЛЭНГЭ АЙМАГ

бүтээгдэхүүний компанийн стандартыг боловсруулахад арга зүйн заавар өгч ажиллалаа.

“Цемент Шохой” ХХК-тай “Хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын гэрээ” байгууллаа.

Жавхлант сумын Эрүүл мэндийн төвийн хэмжих хэрэгслийг ээлжит баталгаажуулалтанд хамруулж, баталгаатай хэмжих хэрэгслээр үйлчлэх нөхцлийг бүрдүүллээ.

Аж ахуй нэгж байгууллага, иргэний үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 10 жин, 6 термометрийг баталгаажуулалтад хамруулсан.

3 айл өрх, нэгжийн 3 ш усны тоолуур, цусны даралтын аппарат 3 ш-ыг тус тус баталгаажуулалтад хамрууллаа.

“ДСЦТС” ХК-тай хамтран Сайхан сумын Хөтөл хотын айл өрх аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа цахилгааны тоолуурыг баталгаажуулахаар ажиллаж байна.

## **Мэргэжлийн хяналтын газар:**

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2016 оны 3 дугаар улирлыг “Төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах улирал” болгон зарлаж 6 ажил төлөвлөн хэрэгжүүлж ажиллалаа.

Батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу 2016 оны 7 дугаар сард Сайхан, Жавхлант сумдад нэгдсэн хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэлээ. Нэгдсэн шалгалтанд 36, зөвлөн туслах үйлчилгээнд 28 хуулийн этгээд, 156 иргэнийг хамруулж, хяналт шалгалтын явцад 140 зөрчил илрүүлж, тэдгээрийг арилгуулахаар 75 заалт бүхий 48 албан шаардлага, 83 заалт бүхий 23 зөвлөмж болон 2 дүгнэлт, 2 акт үйлдэж, илэрсэн зөрчилтэй холбогдуулан 1536.0 мянган төгрөгийн торгууль ногдууллаа.

Монгол улсад зохион байгуулагдах АСЕМ-ын уулзалтын аюулгүй байдлын хангуулах ажлын хүрээнд тэсэрч дэлбэрэх бодис, химийн хорт болон аюултай бодис ашиглан үйл ажиллагаа явуулдаг 15 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд аймгийн Цагдаагийн газар, Тагнуулын газар, Онцгой байдлын газартай хамтарсан хяналтыг гүйцэтгэж, ямар нэг зөрчилгүй ажилласан.

## **Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

6-р сарын 30-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	8,980,732.2	7,445,198.0	82.9
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	7,068,617.1	6,096,493.6	86.2
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	36,577,534.5	33,486,823.5	91.6
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	7,918,539.7	6,637,194.5	83.8
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	1,584,648.2	746,886.1	47.1
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	426,756.8	146,756.8	34.4
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	451,489.7	358,738.8	79.5
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	3,730,443.1	1,695,360.1	45.4
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	1,138,200.0	1,138,200.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	23,180,156.2	23,180,156.2	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	12,243,029.0	12,243,029.0	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	6,001,604.6	6,001,604.6	100.0



# СЭЛЭНГЭ АЙМАГ

	- Эрүүл мэнд, спортын байгууллага	3,158,928.4	3,158,928.4	100.0
	- Соёлын байгууллагуудын	1,519,784.9	1,519,784.9	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	108,043.7	108,043.7	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	148,765.6	148,765.6	100.0
<b>6</b>	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	23,025,315.1	23,025,315.1	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	12,088,187.9	12,088,187.9	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	6,001,604.6	6,001,604.6	100.0
	- Эрүүл мэнд	2,455,126.6	2,455,126.6	100.0
	- Өрхийн эмнэлэг	275,373.0	275,373.0	100.0
	- Спортын байгууллага	428,428.8	428,428.8	100.0
	- Соёлын байгууллагуудын	1,519,784.9	1,519,784.9	100.0
	- Газрын харилцаа кадастрын алба	108,043.7	108,043.7	100.0
	- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	148,765.6	148,765.6	100.0
<b>7</b>	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	1,649,784.5	1,595,368.0	96.7
<b>8</b>	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2,238,085.8	943,261.5	42.1
<b>9</b>	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	437,613.5	309,186.1	70.7
<b>10</b>	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	192,045.2	154,854.2	80.6
<b>11</b>	Тусгай сангуудын зарлага	4,477,181.3	647,855.4	14.5

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2016 V- cap	2016 VI- cap	<u>2016-VI</u> 2016-V
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	Талх, гурил, будаа			
	Гурил /савласан, кг/	1200	1200	100
	Талх /орон нутгийн, ш/	1100	1100	100
	Нарийн боов /кг/	2300	2300	100
	Будаа /кг/	2200	2200	100
	Элсэн чихэр /кг/	1800	1800	100
<b>2</b>	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6500	6200	95.4
	Үхрийн мах /кг/	8500	7500	88.2
	Адууны мах /кг/	6500	6000	92.3
	Ямааны мах /кг/	6200	5500	88.7
	Дотор мах, цувдай /цусгүй/	4500	4500	100.0
	Хиам /чанасан, кг/	9500	9500	100.0
<b>3</b>	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1000	800	80
	Сүү / савласан, л/	2500	2500	100
	Тараг /задгай, л/	1300	1000	77
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	10000	10000	100
	Айраг /л/	3500	3500	100
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	100
	Өндөг /ш/	300	300	100
<b>4</b>	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	3400	3400	100



# СЭЛЭНГЭ АЙМАГ

	Өөхөн тос /кг/	1500	1500	100
	Шар тос /кг/	9000	9000	100
	Масло /задгай, кг/	5000	5000	100
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	1000	1300	130
	Лууван /кг/	2000	2500	125
	Манжин /кг/	2500	3000	120
	Байцаа /кг/	1800	2000	111
	Сонгино /кг/	2000	2000	100
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3000	3000	100
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2500	2500	100
<b>2</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1480	1480	100.0
	Бензин А - 92	1580	1580	100.0
	Дизелийн түлш	1690	1690	100.0

## Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

### **Архивын талаар:**

Архивын ерөнхий газрын Улсын байцаагчийн 2016 оны 05/22 тоот дүгнэлт, илтгэх хуудсын дагуу улсын үзлэгийн мөрөөр хийж гүйцэтгэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулсан.

Мөн нягтлан шалгалт болон нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Төрийн архивын AMS программд Шүдэнзний үйлдвэрийн хөмрөгийн 11 хадгаламжийн нэгжийн 1547 хуудасны баримтын мэдээллийг уншиж заалт 1451, хүний нэр 6119, байгууллагын нэр 25, газарзүйн нэр 63 шивж ашиглалтын хувьтай холбох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Албан байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу архивын хуулбар 88, тодорхойлолт, магадлагаа 66, цалингийн тодорхойлолт 3-ыг гаргаж үйлчиллээ.

## Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

### **1. Эрүүл мэнд, биеийн тамирын талаар:**

2006 онд Энх тайвны корпус, Аймгийн нэгдсэн эмнэлгийн Чанарын албатай хамтран “Сэтгэц нөхөн сэргээх хөдөлмөр эмчилгээ”-ний 2,9 сая төг бичил төслийг хэрэгжүүлсэн бол уг төслийн үргэлжлэл болох Сэтгэцийн тасаг, Чанарын Албатай хамтран “Гэгээн ирээдүй” 2 дахь төслийг 2016 онд хэрэгжүүлж эхэллээ.

Жавхлант сум, Дулаанхаан тосгоны 40-с дээш насны хүн амд халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг хийхээр төлөвлөж, төсөл бичиж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлээд байна.

Сэлэнгэ аймгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 2017 онд хэрэглэх жирэмснээс сэргийлэх эм хэрэгслийн захиалгыг сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн Эрүүл мэнд, спортын яаманд хүргүүллээ.

Түшиг, Жавхлант, Алтанбулаг, Шаамар, Баянгол сум, Хэрх тосгоны эрүүл мэндийн төвүүдийн хэрэгцээ шаардлагын дагуу нийт 8 эмчийг шинээр томилон ажиллуулж байна.

### **2. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:**

2016 оны 06-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 755 байсан бол 148 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 5 ажлын байранд 2 хүнийг ажилд



зуучилж, идэвхгүйн улмаас 148 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 753 боллоо байна.

2016 оны 06 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд Монгол Улсын Засгийн газраас баталсан “Сайн дадлагажигч” хөтөлбөрийн хүрээнд Япон Улсад дадлагажигчаар ажиллах сонирхолтой 466 иргэнийг бүртгэж, бүртгэлийн материалыг Дадлагажигч ажилтан гадаадад илгээх төвд хүргүүлэн ажиллалаа.

2016 оны 07 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд сумдын хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах нэгдсэн сургалт, семинарыг зохион байгууллаа.

### **3. Хүүхэд залуучуудын талаар:**

Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаанд унаач хүүхдийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хангаж, аймгийн нийт сумдад аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар чиглэл, зөвлөмжийг хүргүүлж, хяналт тавьж ажиллалаа.

Үндэсний их баяр наадмын нээлтийн арга хэмжээнд морин хуурын “Таван хан” хамтлагийн 56, Түнхэл тосгоны “Эрдэнэс-5” бүжгийн хамтлагийн 30, Сайхан сумын уран нугаралтын “Нарны охид” -13, “Бөртэ чоно гоо марал” хамтлагийн 16 нийт 120 хүүхэд оролцлоо.

Олон Улсын “Алтаргана-2016 бүх Буриадын 12 дугаар их наадмын номын үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.

### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

Аймгийн хэмжээгээр 128499 га талбайд уринш бэлтгэсэнээс 35609 га-д механик, 92890 га-д химийн уринш бэлтгэсэн байна.

Мандал, Баянгол, Зүүнбүрэн, Шаамар, Орхон зэрэг сумдын эрт ургацын төмс, хүнсний ногоог Улаанбаттар хотын дүүргүүдэд худалдаалахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллав.

Энэ онд 48,2 мян.тол хонь, 7,4 мян.тол ямаа нийт 55,6 мян.тол бог малд ангилалт, 10,9 мян.тол хээлтүүлэгч малд үзлэг хийж, 1,1 мян.тол хээлтүүлэгч мал шинээр тавьсан байна. Үзлэг, ангилалтын тайлан мэдээг гаргаж Мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлээ.

Малын зүй бусын хорогдол, төл бойжилтын эцсийн мэдээг сумдаас авч нэгтгэн Мал эмнэлэг, үржлийн газарт хугацаанд хүргүүлсэн.

Бод малын хээлтүүлэгийн явцын мэдээг сумдаас авч нэгтгэн Мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэв. Хагас жилийн байдлаар нийт бод малын 43% нь хээлтүүлэгт ороод байна.

Алтанбулаг, Мандал, Сүхбаатар, Зүүнбүрэн, зэрэг сумдаас ирсэн мал амьтны халдварт өвчний сэжиг бүхий дуудлага бүрт шуурхай зөвөлгөө зөвлөмжийг өгч, шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

Ийлдэс судлалын шинжилгээнд Сүхбаатар, Орхон, Хушаат, Зүүнбүрэн, Шаамар, Жавхлант зэрэг сумдаас ирсэн 1396 цусны дээж, Нян судлалын шинжилгээнд Зүүнбүрэн, Мандал, Алтанбулаг зэрэг сумдаас ирсэн өвчний сэжигтэй үхсэн малаас авсан эмгэгт дээжинд микроскоп, бактериологийн шинжилгээг хийж халдварт өвчний үүсгэгч илрээгүй тул хариуг зохих газарт нь хүргүүлсэн.

Худалдан борлуулагдаж буй төв нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж байгаамал, аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний Адууны махны 4 дээж, 368 кг, үхрийн махны 42 дээж, 1935 кг, хонины махны 92 дээж 4145 кг, ямааны махны 12 дээж 645 кг, гахай 10 дээж 630 кг өндөгний 10 дээж, сүүний 350л, тараг 20, дайвар 25 дээжинд тус тус МЭАЦ-ийн магадлан шинжилгээг хийж баталгаажуулж гэрчилгээ олгов.



## **Зургаа. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:**

### **1. Газрын харилцааны талаар:**

2016 оны иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг баталсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засгийн газрын тогтоолын дагуу Алтанбулаг сумын 3-р баг Номтын ам, Шар хадатын амны урд хэсэгт төлөвлөсөн газарт газар өмчилж авах иргэдийн өргөдөл хүсэлтийг 2016 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт хүлээн авч эхсэлсэн бөгөөд тус газарт нийт 193 иргэн хүсэлтээ гаргаад байна.

Шинээр газар өмчилж авсан 18, газар эзэмших эрхээ баталгаажуулсан 1, худалдах худалдан гэрээгээр өмчлөх эрхээ шилжүүлсэн 3, өмчилсөн газраа бэлэглэсэн 1 иргэнийг Land manager 2 программд бүртгэн газар нэгж талбарын хувийн хэрэг үүсгэн баяжилт хийж Улсын бүртгэл, статистикийн газарт шилжүүллээ.

Газар эзэмших, ашиглах эрхээ арилжааны болон банк бус санхүүгийн байгууллагад зээлийн барьцаанд тавих хүсэлт гаргасан нийт 10 иргэн, 1 аж ахуйн нэгжийн нийт 16 газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалсан тухай улсын бүртгэлд бүртгэж аймгийн төрийн сангийн 130000941 тоот дансанд 160,000 төгрөгийг төвлөрүүллээ.

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 1 эзэмшигч компаны нийт 202,34 га газарт 2016 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 1637.9 мянган төгрөгийн газрын төлбөрийг ногдуулан газар эзэмших, ашиглах гэрээг байгуулаа.

### **2. Барилга, хот байгуулалтын чиглэлээр:**

2012 онд эхэлсэн Мандал суманд баригдаж байгаа 560 хүүхдийн сургуулийн барилга болон 100 ортой дотуур байрны царцсан барилга угсралтын ажлыг эхлүүллээ. Мөн Мандал сумын 3-р багт баригдсан 60 хувийн гүйцэтгэлтэй 100 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлын чанар байдалд аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран үзлэг шалгалт хийж, дүгнэлт гаргалаа.

Сүхбаатар сумын 5-р багийн 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч байгууллагад дутуу ажил болон чанаргүй хийгдсэн дээврийн эвдрэл гэмтлээс үүдэлтэй эвдрэлийг гүйцээж засварлах талаар албан шаардлага хүргүүллээ.

Мандал сумын цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх ажил болон Зүүнбүрэн сумын нийтийн халуун усны барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг олголоо.

## **Долоо. Байгаль орчны чиглэлээр**

Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Түшиг, Орхонтуул, Баянгол сумдын байгаль хамгаалагчдын үйл ажиллагаанд нэгдсэн хяналт, шалгалтын ажлыг зохион байгууллаа.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах ажлын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас мэдээлэл авах санал хүсэлтийн хайрцгийг Байгаль орчин, аялал жуулчлалын газраас байгууллагадаа байршууллаа.

7-р сарын 21-ны байдлаар: 9, 10, 11, 17, 20-нд нийт нутгаар, 6-нд нутгийн баруун хэсгээр, 7-нд өмнөд хэсгээр, 14-нд нутгийн өмнөд болон зүүн хэсгээр, 18, 19-нд хойд хэсгээр 0,0-34,0 мм бороо орлоо. Бусад хугацаанд бороо ороогүй.

Ихэнх хугацаанд салхи баруун болон баруун хойноос 5-10 м/сек байв.

I-р арав хоногт шөнөдөө 11-16 градус өдөртөө 28-33 градус, II-р арав хоногт шөнөдөө 13-18 градус, өдөртөө 24-29 градус дулаан байлаа.



# СЭЛЭНГЭ АЙМАГ

7 сарын 21-ний өдрийн байдлаар Сэлэнгэ мөрний усны түвшин олон жилийн дунджаас 73-158 см-ээр их, Орхон гол усны түвшин олон жилийн дунджаас 11-41 см-ээр их, Ерөө гол Ерөө сум орчим олон жилийн дунджаас 2 см-ээр их байгаа бол, Ерөө гол Дулаанхан сум орчим 19 см-ээр бага, Хараа гол Баянгол сум орчмоор усны түвшин 6 см-ээр бага, Хүдэр голын усны түвшин олон жилийн дунджаас 13 см-ээр бага, Зэлтэр гол Түшиг сум орчмоор усны түвшин олон жилийн дунджаас 16 см-ээр их байсан. Орхон гол Орхон сум орчим усны түвшин олон жилийн дунджаас 41 см-ээр их, үерийн аюултай түвшинөөс 24 см-ээр их байна.

Бэлчээрийн болон таримал ургамлын өндөр, ургалтын балл: Ургамлын өндөр 12-57см, нийт нутгийн 70 гаруй хувьд зуншлага хэвийн, Мандал, Алтанбулаг, Зүүнбүрэн сумдын нутгаар зуншлагын байдал дунд байна. Улаанбуудайн ургалтын байдал ихэнх сумдын нутгаар сайн, Зүүнбүрэн цэцэглэлт, бусад сумдын нутгаар түрүүлэлтийн үе шатанд орсон.

Хөрсний чийгшил: Улаанбуудайн талбайн 0-20см-т бүх сумдын нутгаар дунд, 0-50см Орхонтуул хангалттай, бусад сумдын нутгаар дунд, 0-100см-ийн гүнд Цагааннуур, Орхонтуул хангалттай, бусад нутгаар дунд, Бэлчээрийн талбайд 0-20см-т хангалтгүй, 0-50см Орхон, Ерөө хангалтгүй, Баянгол дунд байна.

Сүхбаатар суманд агаарын бохирдол, гадаргын усны гидрохимийн шинжилгээ, цацрагийн түвшин нь стандарт хэмжээнээс хэтрээгүй байна. Агаар дахь түгээмэл бохирдуулагч хий болох азотын давхар ислийн дундаж агууламж  $0.029 \text{ мг/м}^3$ , хамгийн их агууламж  $0,050 \text{ мг/м}^3$ , хүхэрлэг хийн дундаж агууламж  $0,002 \text{ мг/м}^3$ , хамгийн их агууламж  $0,05 \text{ мг/м}^3$  байв.

## Найм.Сум орон нутгийн талаар:

### **1.Баянгол сум:**

“И айни еэ Ёо ааюд í ààààì , Àðäüí õóäüñæëüí 95 æëëëéí íéí áàüðüí çáýð òàðëóòëàãòàé ýðäç, ææçç ãæëëóòëàò òòòàé сумын Засаг даргын 2016 оны А/120 тоот захирамж гарч нийт 27 албан хаагч хуваарийн дагуу эргүүл жижүүрийн ажлыг цагдаагийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэлээ.

Цаг агаар болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан гарах гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд хугацаа алдалгүй мэргэжлийн байгууллагуудад мэдээлэн, яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг бэлэн байлгахад анхаарч сэрэмжлүүлэг, цаг агаарын анхааруулга мэдээг нийтэд мэдээлэн ажилласнаар сумын хэмжээнд онц ноцтой шалтгаан нөхцөл гараагүй хэвийн байлаа.

“Монгол ВИ.И.ТИ.НЕТ” төрийн бус байгууллага нь “Боловсрол хөгжил төсөл”-ийг хэрэгжүүлэн сумдын сургуулийн сурагчдын зуны амралтыг үр өгөөжтэй өнгөрүүлэх, тэдний танхимаар олж авсан англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, мөн сурагчдад эерэг зан төлөвшил олгох сургалтыг сургуулийн захиргаа хамтран зохион байгууллаа.

### **2.Баруунбүрэн сум:**

Тайлант сард үндэсний их баяр наадмын өдрүүд тохиосонтой холбогдуулж, сумын Засаг даргын 2016 оны А/94 дүгээр захирамж гарч төр, төсвийн байгууллагуудад үүрэг даалгавар, ард иргэдэд анхааруулга өгч ажиллалаа. Тус захирамжийн дагуу төсвийн байгууллагууд хариуцлагатай эргүүл, жижүүрийг томилон гаргаж ажиллуулсан бөгөөд багийн Засаг дарга нар ард иргэдэд цаг агаарын сэрэмжлүүлэгийг хүргэж ажиллалаа.



# СЭЛЭНГЭ АЙМАГ

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг бага Гонгорын Бумбаны тахилга арга хэмжээ 06 дугаар сарын 30, 07 дугаар сарын 01, 02 ны өдрүүдэд болж өнгөрлөө. Хурал номыг Амарбаясгалант хийд 3 өдөр уншиж уг хурлын үеэр сүсэгтэн олон мөргөлчид олноор цугладаг учир Баруунбүрэн сумын Засаг даргын Тамгын газар, Хөтөлийн сум дундын цагдаагийн тасагтай хамтран нийгмийн хэв журмыг сахиулах, хог хаягдал ихээр хаяж байгаль орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийллээ.

Сумын Засаг даргын 2016 оны А/39 тоот мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай захирамжийн дагуу халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг бод 6413, бог 11830, амьтан 608 бүгд 18851 толгой мал амьтанд хийсэн байна.

Газар тариалан эрхэлж буй аж ахуй нэгжүүд 11000 га талбайд уриншийн боловсруулалтыг хийгээд байна. Үндэсний боловсруулах үйлдвэрт хонины ноос тушаасан малчин болон мал бүхий иргэдийн баримт материалыг хоршооны эзэд болон малчдаас хүлээн авч шивэлт баримт бичгийг бүрдүүлэн Сэлэнгэ аймгийн Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд газарт хүлээлгэн өглөө.

### **3.Жавхлант сум:**

Аймгийн засаг даргын 2016 оны 01 тоот албан даалгаврыг үндэслэн сумын Засаг даргын 01 тоот албан даалгавар, сумын Засаг даргын захирамж гарч ажлын хэсэг байгуулагдан сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж, 7 хоног бүр биелэлтийг тооцон ажиллаж байна.

Эрүүл мэндийн төвд нийт 216 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх 54, амбулаторын үзлэг 41, идэвхитэй хяналт 39, гэрийн идэвхитэй үзлэг 82-бийж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвлөгөө өгч ажиллалаа.

Больницод шинээр 12 хүнийг хэвтүүлэн, холын дуудлага 20, ойрын дуудлага 71 хүлээн авч эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлсэнээр иргэдээс санал гомдол гараагүй байна.

Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас 7 дугаар сард өндөр настан 197 тэтгэвэр авагчид 53701.8 мянган төгрөг, тахир дутуу 65 тэтгэвэр авагчид 15155,6 мянган төгрөгийн тэтгэвэр, тэжээгчээ алдсан 13 тэтгэвэр авагчид 3018.0 мянган төгрөгийн тэтгэвэр, цэргийн 3 тэтгэвэр авагчид 1422.3 мянган төгрөгийн тэтгэвэр, нийт 271 тэтгэвэр авагчид 73297.7 мянган төгрөгийг олголоо.

### **4.Зүүнбүрэн сум:**

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 5, нас баралтын 2, иргэний үнэмлэх олголт 38, шилжин явсан 17, шилжин ирсэн 5, биеийн давхцахгүй өгөгдлийн 8, иргэний үнэмлэх дахин олголтын 5 нийт 80 төрлийн бүртгэлийн ажлыг гүйцэтгэлээ.

Орчиндоо аюул учруулж болзошгүй амьтаныг хараа хяналттай байлгаж, нохойг өглөөний 7<sup>.00</sup> цагаас оройны 23<sup>.00</sup> цагийн хугацаанд уяатай улаан өнгийн хүзүүвчтэй байлгах талаар сумын нохой бүхий өрхүүдэд мэдэгдэл хүргүүлж ажиллалаа.

Тайлант сард сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Хүүхэд залуучуудын спорт тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн нээлтийн үйл ажиллагаанд зориулан сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж 60 гаруй хүүхэд залуучууд оролцлоо.

Амбулатороор 171 иргэнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэнээс өвчний учир 80, урьдчилан сэргийлэх үзлэгээр 28, диспансерийн хяналтаар 21, гэрийн идэвхтэй эргэлтээр 16, дуудлагаар 26 иргэнийг үзлээ.

### **5.Ерөө сум:**





# СЭЛЭНГЭ АЙМАГ

Нийтээр амрах өдрүүдээр иргэд голд усанд орж эндэхээс урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах, согтуугаар авто машин жолоодох, хог хаягдал үүсгэж буйд сумын Засаг даргын Тамгын газар, цагдаа нар хамтран 3 удаа эргүүл шалгалт хийж ажиллалаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас Үндэсний их баяр наадам болсонтой холбогдуулан хүнсний дэлгүүрүүдийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт хийж худалдаа үйлчилгээний газрын MNS 5021:2007 стандартын дагуу мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллалаа.

Ерөө сумын Засаг даргын 2016 оны “Хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуу Могойн гол, Цамхагын гол, Өлөнтийн гол, Харганатын голын чиглэлд сумын Засаг даргын Тамгын газраас 2016 оны 07 дугаар сарын 1-15-ны өдрүүдэд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтын явцад 5 экскеватор, 2 ковшны залах механизмыг лацдаж битүүмжлэн, дээрхи газруудад байгаа техникийн судалгааг гаргалаа. Могойн голд зохих зөвшөөрөлгүйгээр алт олборлож байсан иргэдийн үйл ажиллагааг зогсоож, үйл ажиллагаа явуулж байсан техникүүдийг тус тус лацдаж битүүмжлэв.

## **5.Сайхан сум:**

2016 оны 07 дугаар сарын 09-ний өдөр тус суманд үйл ажиллагаа явуулж буй “Чойжилпилжэлэн” хийдийн санаачилснаар Гавшгай хайрханы тахилгыг амжилттай зохион байгууллаа.

Тус сумын Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Сэтгэл судлалын үндэсний төвтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сургалт зохион байгууллаа.

Хараа, Ерөө голын сав газрын захиргаанаас ирүүлсэн 2016 оны 77 тоот албан шаардлагын дагуу сумын Засаг даргын Тамгын газраас Ширээ нурууны гүүрний орчим зөвшөөрөлгүй гэр гуанз ажиллуулж буй Дархан-Уул аймгийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, сав газрыг яаралтай чөлөөлөх талаар мэдэгдэл хүргүүллээ.

Номгон тосгоны гудамжны гэрэлтүүлэгийн ажил, Хөл бөмбөгийн талбайн ажил, гудамжны гэрэлтүүлэгийн ажлуудын тендерийг тус тус зарласан бөгөөд Номгон тосгоны гэрэлтүүлэгийн ажлыг хугацаанд нь хүлээж авлаа.

## **6.Сүхбаатар сум:**

Их Монгол Улс байгуулагдсаны 810, Ардын хувьсгалын 95 жилийн ойн хүрээнд Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газраас “Бид нэг сумынхан” өдөрлөгийг 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдөр зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд үндэсний бөхийн цол олгох 64 бөхийн барилдаан, мото спортын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газраас улсын баяр наадмаар нийтийн хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд хяналт тавьж иргэдэд хоол, хүнсээр дамжих халдвараас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, санамжийг хүргүүллээ.

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, тус сумын Засаг даргын Тамгын газар хамтран Озон задалдаг фторт нүүрс төрөгчийн төрлийн хөргөх бодис, түүнийг орлуулах бодисын тооллогыг хийж гүйцэтгэлээ.

Соёлын өвийг хамгаалах зорилгоор зэргэлдээх суманд хууль бус хиргисүүр малтлага гарсантай холбогдуулан өөрийн суманд хамааралтай хүннүгийн үеийн дөрвөлжин булш, хиргисүүр хөшөө дурсгал, суврага зэрэг холбогдох зүйлст ажлын хэсэг гарган хяналт шагалт хийж байна.

## **7.Хушаат сум:**



# СЭЛЭНГЭ АЙМАГ

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажил дуусч хүлээн авлаа.

Тус сумын 30 жилийн ой 2017 онд тохиохтой холбогдуулан “Хушаат сумын хөгжил” санг байгуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлууллаа.

Нийгмийн даатгалын шимтгэлд 23 байгууллага, аж ахуйн нэгжийн 108626.4 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 123 хүний 16367.6 мянган төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 156 хүний 5130.2 мянган төгрөгийн хураамжийг тус оруулжээ.

Шинээр тэтгэвэр тогтоолгох 12, шилжин ирсэн 1, ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцоход 6 хүний материалыг хүлээн авч шийдвэрлэн тэтгэвэр тогтоолгох зөвлөгөөг 79 хүнд, Эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах зөвлөгөөг 635 хүнд өгчээ.

Сумын эрүүл мэндийн төвд төрөлт 1, ор хоног 100, үзлэгийн тоо 110, 0-5 насны жинэлсэн хүүхдийн тоо 84, түргэн тусламжийн дуудлага 58, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхэд 31, шинжилгээнд хамрагдсан хүн 21, умайн хавдар хөхний хавдар илрүүлэг үзлэгт хамрагдсан хүн 10, чихрийн шижин хэв шинж эрт илрүүлэг, артерийн гипертензи эрт илрүүлэгт тус бүр 3 хүн хамрагджээ.

## **8.Орхон сум:**

Ардын хувьсгалын 95 жилийн ой, сумын баяр наадмыг тус сумын Засаг даргын А/111 тоот захирамжаар 2016 оны 7 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Сумын баяр наадмын өдөр аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сумын наадмын талбайн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж төр төсвийн албан байгууллагууд болон сумын ахмадын хороо, уяачдын холбоо хамтран наадамчин олонд хүндэтгэл үзүүлж жагсаал зохион байгууллаа.

2016 оны 07 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Ө.Жадамбаагийн үр хүүхдүүдээс үе үеийн тариаланчдын дурсгалд зориулан бүтээсэн “АЛТАН ТҮРҮҮ” хөшөөг бүтээж сум орон нутгийн удирдлагуудад хүлээлгэн өгч хөшөөний нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 5 өрхийн 45 иргэнд 6-р сарын хүнсний эрхийн бичгийг олгож нийт 286000 төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Баруунбүрэн сумаас бэлтгэх хэрэглээний модны хуваарийн дагуу иргэдийн нэрсийг бүртгэн эхний ээлжний 40 иргэний 364м.куб хэрэглээний модны захиалгыг Баруунбүрэн суманд хүргүүлж, бэлтгүүлж эхэллээ.

## **9.Шаамар сум:**

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд малын боом өвчнөөс урьдчилан сэргийлж нийт 23900 толгой мал, 1500 толгой амьтан дархлаажуулалтанд хамрагдаж мал амьтан эрүүл мэндийн дэвтэрт хяналт тавьж ажиллалаа.

Нийгмийн даатгалын санд хагас жилийн байдлаар 154092.20 мянган төгрөгийн орлого хуримтлуулах төлөвлөгөөтэйгээс 174490.85 мянган төгрөгийн орлого оруулж, биелэлт 113.2 хувь б $\ddot{a}$ а $\ddot{u}$ д $\ddot{a}$ э  $\grave{a}$ а $\acute{e}$ и  $\grave{a}$ .

2016 оны 7 дугаар сарын байдлаар Шаамар сумын 1, 2-р багийн хэмжээнд шинээр төрсөн эрэгтэй 2, эмэгтэй 2 хүүхэд төрж, нийт 4 хүүхэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олголоо. Бусад аймаг руу шилжин явсан 3 иргэн, бусад, аймаг, сумаас 2 иргэн өөрийн хүсэлтийн дагуу шилжин ирж, нас барсан 2, гэрлэлтийн батлах авах хүсэлт гаргасан 1 иргэдийн бүртгэлийг тухай бүр бүртгэлийг хийлээ.



# СЭЛЭНГЭ АЙМАГ

Сумын хэмжээнд 12 иргэн ажил хайгч иргэнээр бүртгүүлж 2 иргэн төр төсвийн байгууллагуудад ажлын байранд зуучиллаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР